

## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025 оны 05 сарын 14 өдөр

Дугаар 25 /12

Улаанбаатар хот

### Компанийн бодлогын баримт бичиг батлах тухай

Компанийн тухай хуулийн 76.1.13, 76.1.18, Компанийн дүрмийн 8.12.13, Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 145 дугаар тогтоол, ТУЗ-ийн 2025 оны 05-р сарын 14-ний өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Бодь Даатгал ХК-д дагаж мөрдөх “Комплайнсын хяналтын заавар”-ийг Хавсралт № 1-р баталсугай.
2. Бодь Даатгал ХК-д дагаж мөрдөх “Бусад оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах бодлогын баримт бичиг”-ийг Хавсралт № 2-р баталсугай.
3. Бодь Даатгал ХК-д дагаж мөрдөх “Хөрөнгө оруулагчтай харилцах хөтөлбөр”-ийг Хавсралт № 3-р баталсугай.
4. Бодь Даатгал ХК-д дагаж мөрдөх “Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх журам”-ийг Хавсралт № 4-р баталсугай.
5. Компанийн Гүйцэтгэх захирал болон холбогдох албан тушаалтуудад батлагдсан дүрэм, журм, бодлогыг чанд мөрдөж ажиллахыг үүрэг болгосугай.
6. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод аудитор Ш.Бэжидэд үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ




Б.БИЛЭГТ



**БОДЬ ДААТГАЛ**  
ЭРСДЭЛИЙГ ДАВАХ ХҮҮ

## БОДЬ ДААТГАЛ ХК-ИЙН ОРОЛЦОГЧ ТАЛУУДАЙ ХАРИЛЦАХ, ХАМТРАН АЖИЛЛАХ БОДЛОГО

ТҮЗ-ийн 2025 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн  
25/12 тоот тогтоолын хавсралт 2



| Бодь даатгал ХК                |   |
|--------------------------------|---|
| Баримт бичгийн төрөл:          | Бодлого   |
| Хөтөлбөр:                      | Оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах бодлого                                      |
| Боловсруулсан нэгж:            | Дотоод хяналтын алба  |
| Хэрэгжүүлэх нэгж:              | Бүх газар нэгж  |
| Хэрэгжилтэд хяналт тавих нэгж: | Дотоод аудит  |
| Нууцын зэрэг:                  | /В/ Компанийн дотоод хэрэгцээнд нууц биш  |
| Журмын дугаар:                 |   |
| Хүчинтэй хугацаа:              | Эхлэх: ТУЗ-ийн тогтоол гарснаар<br>Дуусах: ТУЗ-ийн тогтоол хүчингүй болсонд тооцох хүртэл |
| Хуудасны тоо:                  | 8   |

|                 | Нэр   | Албан тушаал  | Гарын үсэг          |
|-----------------|---|---|---------------------|
| Бэлтгэсэн:      | Д.Наранцэцэг  | ДХХХ-ийн ажилтан  |                     |
| Санал өгсөн:    | Л.Банзрагч<br>А.Энхжаргал<br>М.Мөнхбаатар<br>Х.Сарангоо | ТУЗ-ын хараат бус гишүүн<br>Гүйцэтгэх захирал<br>БХГ-ын захирал<br>Хуулийн хэлтэс |                     |
| Баталсан:       | Б.Билэгт  | ТУЗ-ын дарга  |                     |
| Баталсан огноо: | 2025.05.14  | Ангилал:  | Дотоодын хэрэгцээнд |

БОДЛОГЫН ӨӨРЧЛӨЛТИЙН БҮРТГЭЛ

| № | Бодлогын дугаар | Батлагдсан огноо/<br>тушаалын дугаар | Нэмэлт, өөрчлөлт<br>өрсөн огноо/<br>тушаалын дугаар | Цуцлагдсан<br>огноо/<br>тушаалын<br>дугаар |
|---|-----------------|--------------------------------------|---|--|
| 1 |                 |                                      |   |  |
| 2 |                 |                                      |   |  |
| 3 |                 |                                      |   |  |
|   |                 |                                      |   |  |
|   |                 |                                      |   |  |
|   |                 |                                      |   |  |
|   |                 |                                      |   |  |

|   |   |
|---|---|
| АГУУЛГА:  |   |
| НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ .....                               | 5 |
| ХОЁР. ОРОЛЦОГЧ ТАЛУУД.....                                | 5 |
| ГУРАВ. ОРОЛЦОГЧ ТАЛУУДТАЙ ХАРИЛЦАХ, ХАМТРАН АЖИЛЛАХ ..... | 5 |
| ДӨРӨВ.БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ.....                             | 7 |
| ТАВ. ХЯНАЛТ, САЙЖРУУЛАЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ.....           | 7 |





## НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Энэхүү баримт бичгийг Монгол Улсын Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Компанийн засаглалын кодексийн хүрээнд нээлттэй хувьцаат компанийн үйл ажиллагаанд тавигдах шаардлагад нийцүүлэн боловсруулав.
- 1.2. Энэхүү бодлогын зорилго нь “Бодь даатгал” ХК/цаашид “Компани” гэх/-ийн оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах харилцааг зохицуулахад орших ба харилцах, хамтран ажиллах явцад гарах эрсдэлээс урьдчилан сэргийлэх, сэтгэл ханамжтай хамтын ажиллагааг бий болгоход оршино.

## ХОЁР. ОРОЛЦОГЧ ТАЛУУД

- 2.1. Оролцогч талууд гэж компанийн үйл ажиллагаанд шууд болон шууд бусаар нөлөөлж буй талуудыг/хувь хүн, бүлэг, байгууллага/ хэлнэ.
- 2.2. Компанийн оролцогч талуудад дараах этгээд хамаарна.
  - 2.2.1. Хувьцаа эзэмшигчид
  - 2.2.2. Ажиллагсад
  - 2.2.3. Харилцагчид
  - 2.2.4. Төлөөлөн удирдах зөвлөл
  - 2.2.5. Зохицуулагч байгууллага болон төрийн байгууллага, мэргэжлийн холбоод
- 2.3. Компанийн үйл ажиллагаа оролцогч талууддаа тодорхой нөлөө үзүүлдэг мөн оролцогч талууд компанийн үйл ажиллагаанд өөрсдийн нөлөөг үзүүлдэг гэдгийг хүлээн зөвшөөрч, эрх ашгийг нь хүндэтгэн, хамтран ажиллана.
- 2.4. Компани нь оролцогч талуудтай хамтран ажиллахдаа хууль, дүрэм журам, шударга ёс, ёс зүйн хэм хэмжээг баримтална.

## ГУРАВ. ОРОЛЦОГЧ ТАЛУУДАЙ ХАРИЛЦАХ, ХАМТРАН АЖИЛЛАХ

- 3.1. Хувьцаа эзэмшигч:
  - 3.1.1. Хувьцаа эзэмшигчийг компанийн хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлдэг гэдэг утгаар нь түүний хууль тогтоомжид заасан эрхийг хүндэтгэн тэгш хандаж, компанийн талаар мэдээлэл авах болон хууль болон компанийн дүрэмд заасан эрхээ хэрэгжүүлэх нөхцөлийг бүрэн хангаж, ТУЗ хэрэгжилтэд хяналт тавина.
  - 3.1.2. Хувьцаа эзэмшигчдийн хурлаас гаргасан шийдвэрийн эсрэг саналтай байсан, эсхүл санал хураалтад оролцоогүй хувьцаа эзэмшигчид Компанийн тухай хуульд заасны дагуу өөрийн эзэмшлийн хувьцааг эргүүлэн худалдаж авахыг компаниас шаардах эрхийг хэрэгжүүлэхэд саад учруулахгүй байх, хувьцаа эзэмшигчийн хуульд заасан эрхийг хүндэтгэнэ.
- 3.2. Ажилтан:
  - 3.2.1. Ажилтныг компанийн үйл ажиллагааг хэрэгжүүлэгч гэдэг утгаар нь түүнтэй харилцахдаа хөдөлмөрийн гэрээ, ажлын байрны тодорхойлолтод заасан эрх хэмжээ, үүрэг хариуцлагын хүрээнд харилцана.

- 3.2.2. Ажилтныг ажлаа чөлөөтэй сонгох, эрүүл, аюулгүй орчинд ажиллах, цалин хөлс шударгаар тогтоолгох эрхийг хүндэтгэж, эрхийг зөрчигдөхөөс хамгаалж, зөрчигдсөн тохиолдолд нэн дариу илрүүлж, эрхийг эдлүүлнэ.
- 3.2.3. Хөдөлмөрийн дотоод журамд ажилтны эрүүл мэндийг хамгаалах, нийгмийн асуудлыг шийдэх, мэргэжил дээшлүүлэх зохицуулалтыг тусгах ба хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөтэй байх.
- 3.2.4. Ажилтны гаргасан санал, хүсэлт, өргөдөл, гомдлыг шийдвэрлэхдээ ажилтанд ашигтай байдлаар шийдэх.
- 3.3. Харилцагч:
- 3.3.1. Харилцагчийг компанийн орлогыг бүрдүүлэгч гэсэн утгаар нь тэдний эрхийг хамгаалах зорилго бүхий, байгууллагын соёлыг бүрдүүлж ажиллана.
- 3.3.2. Харилцагчтай харилцах харилцаанд гарсан зөрчил, маргааныг эв зүйгээр тохиролцож, харилцан буулт хийх замаар шийдэх, харилцан тохиролцож шийдвэрлэх боломжгүй тохиолдолд шүүхийн журмаар шийдвэрлэх.
- 3.4. Зохицуулагч байгууллага болон төрийн байгууллага:
- 3.4.1. Зохицуулагч байгууллага, төрийн байгууллагад хүргүүлэх тайлан мэдээг холбогдох хууль тогтоомжид заасан нөхцөл шаардлагыг бүрэн хангасан хэлбэрээр, цаг тухайд нь хүргүүлнэ.
- 3.4.2. Компани зохицуулагч байгууллага болон төрийн байгууллагатай харилцахдаа хууль тогтоомжид хүрээнд харилцана.
- 3.4.3. Зохицуулагч байгууллага, төрийн байгууллагатай харилцах харилцаанд цахим хэрэгслийг түлхүү ашиглана.
- 3.4.4. Төрийн байгууллага, зохицуулагч байгууллагын хүний эрх, эрх чөлөөг хамгаалах ажиллагаанд дэмжлэг үзүүлж хамтран ажиллана.
- 3.5. Компани оролцогч талуудын санаа бодол, хүлээлт, хэрэгцээг ойлгохын тулд тэдний санал, хүсэлт, гомдлыг хүлээн авах сувгаар хангаж, ирсэн санал, хүсэлт, гомдлыг хүлээн авах.
- 3.5.1. Компанийн албан ёсны цахим хуудас [info@bodi-insurance.com](mailto:info@bodi-insurance.com), олон нийтийн сүлжээн дэх <https://www.facebook.com/bodiinsurance.mn> цахим хаягаар дамжуулан цахим хэлбэрээр.
- 3.5.2. Компанийн лавлах утас 75054800 дугаарт холбогдон аман хэлбэрээр.
- 3.5.3. Компанид өөрийн биеэр ирж цаасаар санал хүсэлтээ өгнө.

- 3.6. Оролцогч талуудаас ирүүлсэн гомдол, санал, хүсэлтийг хүлээн авч холбогдох ажилтанд шилжүүлж шийдвэрлүүлэн холбогдох хариуг өгнө.
- 3.7. Оролцогч талуудаас ирүүлсэн өргөдөл гомдлыг шийдвэрлэхдээ мэдээллийн нууцлалыг хангаж, хүний эрхийг хүндэтгэх зарчмыг баримтална.

### **ДӨРӨВ.БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ**

- 4.1. ТУЗ нь оролцогч талуудын ашиг сонирхол, хэрэгцээ шаардлагыг зөв тодорхойлж, тэдгээрийг зохистойгоор тэнцвэржүүлэн ажиллана.
- 4.2. Энэхүү бодлогыг ТУЗ батлах ба Гүйцэтгэх удирдлага нь хэрэгжилтийг хангаж оролцогч талуудын эрх ашгийг хүндэтгэн, тэдэнтэй хамтран ажиллах байгууллагын соёлыг төлөвшүүлнэ.
- 4.3. ТУЗ болон Гүйцэтгэх удирдлага нь бодлогыг хэрэгжүүлэх төсөв хуваарилж, чадварлаг, мэдлэгтэй хүний нөөц болон оролцогч талуудаас санал авах, мэдээлэл бүрдүүлэх тогтолцоогоор хангана. Оролцогч талуудтай байгуулах аливаа гэрээ хэлцлийг энэхүү бодлогын хүрээнд байгуулна.
- 4.4. ТУЗ-ийн дэргэдэх аудит, эрсдэлийн удирдлага хариуцсан хороо нь оролцогч талуудтай холбоотой үүсэж болох эрсдэлүүдийг тодорхойлон, тэдгээрийг удирдах чиглэлийг тогтоож, хэрэгжилтийг хангуулна.

### **ТАВ. ХЯНАЛТ, САЙЖРУУЛАЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ**

- 5.1. “Оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах бодлого”-гийн баримт бичгийг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу ТУЗ-ийн шийдвэрээр баталж, өөрчилж, хүчингүй болгоно.
- 5.2. Энэхүү бодлогын баримт бичгийг хэрэгжилтэд ТУЗ-ийн дэргэдэх аудит хяналт тавьж ажиллана.